



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/33

Пионер толгой

┌ Хүнсний дэлгүүрүүдэд хяналт шалгалт ┐
хийх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Нэгжийн хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.11, Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 8.2.3, 18.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн нь:

1.Европын Хүнс, тэжээлийн холбоо болон олон улсын INFO сүлжээний мэдээллээс Бельги улсад үйлдвэрлэсэн САСНЕТ нэрийн шоколад, Испани улсад үйлдвэрлэсэн АЛМАНД нэрийн самарт хүний биед хортой афлотоксин их хэмжээгээр илэрсэн болох нь тогтоогдсон тул хүнсний дэлгүүрүүдэд хяналт шалгалт хийх ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Ц.Баатаржав	Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах нийгэмлэгийн мэргэшсэн шинжээч
Гишүүд:	Т.Цагаанлянх	Эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтан
	Б.Мөнх-Эрдэнэ	Олон нийтийн цагдаа
Нарийн бичгийн дарга:	М.Ариунсан	Хөдөө аж ахуйн тасгийн дарга

2.Дээрх нэр төрлийн бүтээгдэхүүн илэрсэн тохиолдолд тоо, хэмжээ, аль улсад үйлдвэрлэсэн, хаанаас нийлүүлсэн, битүүмжилсэн тоо хэмжээ зэрэг мэдээллийг нягтлан авч битүүмжлэн ажилллахыг ажлын хэсэгт даалгасугай.

3.Хяналт шалгалт хийсэн тухай тайланг нэгтгэн аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт яаралтай хүргүүлэхийг хөдөө аж ахуйн тасгийн дарга (М.Ариунсан)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Р.Гантулга)-д даалгасугай.

ДАРГА



Б.ГАНТУЛГА 642201245

Е/2023/Засаг дарга/Захирамж2023